



## СУВИЛАГЧ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Гадаад ба дотоодын сургалт эрхлэх эрх бүхий байгууллагын сургалтад мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдсан байх;
2. Эрдэм шинжилгээний хуралд өгүүлэл, илтгэл хэвлүүлсэн нотолгоо баримттай байх /хөтөлбөр, хэвлүүлсэн материалыг эх хувиар хавсаргах/ ;
3. Эрүүл мэндийн чиглэлээр ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, сонин, сэтгүүлд санамж, зөвлөмж хэвлэн нийтлүүлсэн байх /эх хувиар материалыг хавсаргах/;
4. Сувилахуйн тусламж үйлчилгээнд шинэ санаачлага, технологи, бүтээлийг нэвтрүүлж үр дүнг тооцож зургаар баталгаажуулсан байх /Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаар баталгаажсан байх/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ахлах зэрэг хамгаалснаас хойших хугацаанд сувилахуйн тусламж үйлчилгээнд 2-оос доошгүй шинэ технологи, бүтээлийг нэвтрүүлэн үр дүнг тооцож зургаар баталгаажуулсан байх /эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаар баталгаажсан байх /;
2. Эрдэм шинжилгээний хуралд 2-оос доошгүй өгүүлэл, илтгэл хэлэлцүүлж хэвлүүлсэн нотолгоо баримттай байх /хөтөлбөр, хэвлүүлсэн материалыг эх хувиар хавсаргах/;
3. Ахлах зэрэг хамгаалснаас хойших хугацаанд байгууллагын хэмжээнд сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр сургалт, семинарыг зохион байгуулж сонин, сэтгүүлд 2-оос доошгүй нийтлэл хэвлүүлсэн байх /эх хувиар материалыг хавсаргах/;
4. Шинээр төгссөн сувилагч ба суралцагч нарыг дагалдуулан сургаж, туршлагажуулсан байх /сувилахуйн албаны даргаар баталгаажуулна/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сувилахуйн удирдлага болон бусад чиглэлээр 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх /сувилахуйн алба болон хүний нөөцийн менежерийн тодорхойлолт/;
2. Сувилахуйн боловсролын болон мэргэжлийн мэдлэгээ тэргүүлэх зэрэг хамгаалах үеийн түвшнээс ахиулсан үзүүлэлттэй байх;
3. Мэргэжлийн дагуу ном, гарын авлага, DVD, төсөл, хөтөлбөрийн аль нэгийг гаргасан байх;
4. Эрдэм шинжилгээний хуралд 3-аас доошгүй өгүүлэл, илтгэл хэлэлцүүлж хэвлүүлсэн нотолгоо баримттай байх /үүнээс олон улсад 1-ээс доошгүй хэвлүүлсэн материалыг эх хувиар хавсаргах, хөтөлбөр /;
5. Улсын болон байгууллагын хэмжээнд үйлчлүүлэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгож, үр дүнг тооцсон байх /хөтөлбөр, сувилахуйн албаны даргаар баталгаажсан байх/;
6. Мэргэжлийн чиглэлээр өөрийн үнэлгээний тайлантай байх;
7. Сувилагч нарыг сургаж, туршлагажуулсан ололт, амжилт, үр дүнг баталгаажуулсан байх;
8. Тэргүүлэх зэрэг хамгаалснаас хойших хугацаанд сувилахуйн тусламж үйлчилгээнд 3-аас доошгүй шинэ технологи, бүтээлийг нэвтрүүлэн үр дүнг тооцож зургаар баталгаажуулсан байх /эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаар баталгаажсан байх/;